



**МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ БАТЛАН ХАМГААЛАХЫН
ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН
ТУШААЛ**

2024 оны 04 сарын 29 өдөр

Дугаар *10*

Улаанбаатар хот

Журам батлах тухай

“Дээд боловсролын тухай хууль”-ийн 31.1.2, “ҮБХИС-ийн дүрэм”-ийн 11.7.1, 11.7.7, ҮБХИС-ийн Эрдмийн зөвлөлийн 2024 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн хуралдааны 02 тоот тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн дэд профессор, профессор цол олгох журам”-ыг хавсралтаар баталсугай.



2. Энэ тушаал гарсантай холбогдуулан ҮБХИС-ийн захирлын 2018 оны А/364 дүгээр тушаалаар батлагдсан “ҮБХИС-ийн дэд профессор, профессор цол олгох журам”-ыг хүчингүй болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудит чанарын үнэлгээний алба / дэд хурандаа Э.Баттөр/-нд үүрэг болгосугай.


ЗАХИРАЛ
БРИГАДЫН ГЕНЕРАЛ



П.ЖАРГАЛАН

Боловсруулсан:.......... Д.Энхчимэг
Хянасан:хур.......... хур Б.Өлзийхуяг
Хувь:01

ҮБХИС-ийн захирлын 2024 оны
... дүгээр сарын ... өдрийн
... дугаар тушаалын хавсралт



ҮБХИС-ИЙН ДЭД ПРОФЕССОР, ПРОФЕССОР ЦОЛ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагад олон жил үр бүтээлтэй ажилласан, эрдэм шинжилгээ, сургалт, судалгааны дадлага туршлагатай, эрдэм шинжилгээний бүтээл туурвилтай эрдэмтэн, багш нарт ҮБХИС-ийн дэд профессор, профессор цол олгоход энэхүү журмын зорилго оршино.
- 1.2. ҮБХИС-ийн дэд профессор, профессор цол олгох асуудлыг энэхүү журмаар зохицуулна.
- 1.3. Дэд профессор, профессор цолыг их сургуулийн Эрдмийн зөвлөлөөс олгох бөгөөд албан ёсны болон бусад ёслол хүндэтгэлийн үйл ажиллагаанд хэрэглэнэ.

Хоёр. Нийтлэг шаардлага

- 2.1. Дэд профессор цолыг дараах нийтлэг шаардлага хангасан хүмүүст олгоно. Үүнд:
 - 2.1.1. Докторын зэргийг хамгаалснаас хойш гурван жил болсон, ёс суртахууны болон судалгааны ёс зүйн зөрчилгүй байх;
 - 2.1.2. Их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагад 10-аас доошгүй жил тасралтгүй, үр бүтээлтэй ажилласан, үүнээс 5-аас доошгүй жил их, дээд сургуульд багшилсан байх;
 - 2.1.3. Дотоодын хянан магадлагаа хийгдсэн мэргэжлийн сэтгүүлд хэвлүүлсэн өгүүлэл 8-аас доошгүй байх (Докторын зэрэг хамгаалсанаас хойш эрдэм шинжилгээний хуралд 5-аас доошгүй, үүнээс олон улсын эрдэм шинжилгээний хуралд 2-аас доошгүй илтгэл хэлэлцүүлсэн байх);
 - 2.1.4. Докторын зэрэг горилсон судалгааны ажил 1-ээс доошгүй хамтран болон зөвлөхөөр удирдсан, эсвэл магистрын зэрэг горилсон 2-оос доошгүй ажлыг удирдан хамгаалуулсан, 2-оос доошгүй судалгааны ажилд шүүмж бичсэн байх
 - 2.1.5. Олон улсын бусад мэдээллийн санд бүртгэлтэй хянан магадлагаа хийгддэг мэргэжлийн сэтгүүлд 2-оос доошгүй өгүүлэл, ном, илтгэл нэгдүгээр болон холбоо баригч зохиогчоор хэвлүүлсэн байх (докторын зэрэг хамгаалснаас хойш);
 - 2.1.6. Дээд боловсролын сургалтын байгууллагад зориулсан дараах бүтээлийн шаардлагаас нэгийг хангасан байх. Үүнд: сурах бичиг-1, нэг сэдэвт судалгааны бүтээл -1, гарын авлага-5, редакторласан бүтээл 3-аас доошгүй байх;
 - 2.1.7. h индекстэй судлаач багш байх;
 - 2.1.8. Улс, салбарын төсөлд судалгааны ажлын удирдагч эсвэл гүйцэтгэгчээр 2-оос доошгүй судалгааны төсөлт ажил хүлээлгэж өгсөн байх;
- 2.2. Профессор цолыг дараах нийтлэг шаардлагыг хангасан хүмүүст олгоно. Үүнд:
 - 2.2.1. Доктор (Ph.D)-ын зэрэгтэй, дэд профессор цол хүртээд 3-аас доошгүй жил болсон, ёс суртахууны болон судалгааны ёс зүйн зөрчилгүй байх;

- 2.2.2. Их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагад 15-аас доошгүй жил тасралтгүй, үр бүтээлтэй ажилласан, үүнээс 8-аас доошгүй жил их, дээд сургуульд багшилсан байх;
- 2.2.3. Олон улсын шинжлэх ухааны мэдээллийн санд бүртгэлтэй, хөндлөнгийн хянан магадлагаа хийгддэг мэргэжлийн сэтгүүл (Web of Science, Scopus)-д 1-ээс доошгүй өгүүлэл, ном, илтгэл нэгдүгээр эсвэл холбоо баригч зохиогчоор хэвлүүлсэн байх;
- 2.2.4. Олон улсын бусад мэдээллийн санд бүртгэлтэй хянан магадлагаа хийгддэг мэргэжлийн сэтгүүлд 3-аас доошгүй эрдэм шинжилгээний өгүүллийг нэгдүгээр эсвэл холбоо баригч зохиогчоор хэвлүүлсэн);
- 2.2.5. Дотоодын мэргэжлийн сэтгүүлд хэвлүүлсэн өгүүлэл 30-аас доошгүй үүний 8-аас доошгүй нь дэд профессор цол хүртсэнээс хойш байх;
- 2.2.6. Мэргэжлийн дагуу шавь сургуулийн үндэс суурь бэлтгэж 2-оос доошгүй докторантын эрдэм шинжилгээний ажил удирдсан докторын зэрэг хамгаалуулсан байх;
- 2.2.7. h индекстэй судлаач багш байх (Олон улсын мэдээллийн санд бүртгэлтэй сэтгүүлд хэвлүүлсэн өгүүлэлээс нь авсан эшлэлийн тоо 3-аас доошгүй байх);
- 2.2.8. Дээд боловсролын сургалтын байгууллагад зориулсан сурах бичиг, гарын авлага, нэг сэдэвт судалгааны бүтээл 3-аас доошгүй байх;
- 2.2.9. Олон улсын, улс, салбарын судалгааны төсөлт ажлын удирдагчаар 1-ээс доошгүй эсвэл төслийн гүйцэтгэгчээр оролцсон ажил 3-аас доошгүйг хүлээлгэж өгсөн байх;
- 2.2.10. Шинжлэх ухааны ба сургалтын бүтээлийн зохиогчийн эрх-3 эсвэл тухайн мэргэжлийн чиглэлийн шинэ бүтээлийн болон ашигтай загварын патент -2 -оос доошгүй байх;

Гурав. Профессор, дэд профессор цол олгоход бүрдүүлэх материал

- 3.1. Профессор, дэд профессор цолд нэр дэвшүүлэхэд дараах материалыг бүрдүүлнэ.
 - 3.1.1. Анкет (Төрийн албан хаагчийн маягт I маягт);
 - 3.1.2. Тодорхойлолт (Нэр дэвшигчийн сургалт, эрдэм шинжилгээний ажил, багшлах ур чадвар, мэргэжлийн болон олон нийтийн үйл ажиллагаанд хэрхэн оролцдог, нэр дэвшүүлж буй үндэслэл зэргийг оруулсан байна.);
 - 3.1.3. Тэнхим (төв)-ийн хурал, бүрэлдэхүүн сургуулийн Эрдмийн зөвлөлийн хурлын шийдвэр;
 - 3.1.4. Бүрэлдэхүүн сургуулийн Эрдмийн зөвлөлийн эрдэмтэн нарийн бичгийн дарга хянаж баталгаажуулсан бүтээлийн жагсаалт;
 - 3.1.5. Докторын зэргийн болон дэд профессор цолны дипломын хуулбар (нотариатаар баталгаажуулсан) ;
 - 3.1.6. Докторын диссертаци, магистрын ажил удирдаж хамгаалуулсан тухай нотлох тушаалын хуулбар.

ДӨРӨВ. ПРОФЕССОР ЦОЛ ОЛГОХ

4.1. Харьяаллын сургуулийн Эрдмийн зөвлөлийн хурлын шийдвэрт үндэслэн нэр дэвшигч багш нарын материалыг бүрдүүлж ҮБХИС-ийн Эрдмийн зөвлөлд ирүүлнэ.

4.2. ҮБХИС-ийн Эрдмийн зөвлөл нь профессор, дэд профессор цолны шаардлага хангасан тухай хүсэлт, материалыг хүлээн авч үнэлэн, эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн нууц санал хураалтаар нийт гишүүдийн 75 ба түүнээс дээшээс хувийн саналаар шийдвэрлэнэ. Хангалттай санал аваагүй тохиолдолд нэр дэвшигч 2 жилийн дараа дахин нэр дэвших эрх нээгдэнэ.

4.3. Тухайн цол олгох журамд шаардлага хангаагүй, хуурамч бичиг баримт бүрдүүлсэн тохиолдолд материалыг буцаах, бүрэлдэхүүн сургуулийн Эрдмийн зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга нарт хариуцлага тооцно.

4.4. Шинжлэх ухаан технологийн санд хадгалагдаж буй эрдэмтдийн мэдээллийн санд үндэслэн тухайн их сургуулийн Эрдмийн зөвлөлийн нарийн бичгийн дарга, эрдэмтэн, багш, судлаач нарын эрдэм шинжилгээ, судалгааны ажлын бүтээлийн жагсаалтыг хянан баталгаажуулж, сургуулийн архивт хадгална.

ТАВ. БУСАД ЗҮЙЛ

5.1. Профессор, дэд профессор цол олгох холбогдох зардлыг ҮБХИС-ийн Эрдмийн зөвлөлийн шийдвэрийг үндэслэн захирлын тушаалаар олгоно.

5.2. Профессор, дэд профессор цолны үнэмлэхийг хавсралтын дагуу хэвлүүлнэ.

5.3. Профессор, дэд профессор цол олгосон цол олгосон шийдвэрийг сургуулийн нэгдсэн бүртгэлд бүртгэнэ.

5.4. Профессор, дэд профессор цол цолыг шаардлага зөрчиж олгосон нь нотлогдвол ҮБХИС-ийн Эрдмийн зөвлөлийн шийдвэрийг үндэслэн захирлын тушаалаар цолыг хүчингүй болгоно.

5.5. Журмын хэрэгжилтэд ҮБХИС-ийн Дотоод аудит, чанарын үнэлгээний алба хяналт тавьж ажиллана.